

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

ОРШИЛ

Хүүхэд бүр төрсөн цагаасаа эхлэн хүний язгуур эрх, эрх чөлөөг эдлэх ёстой. Энэ бол дэлхийн хүүхэд багачууд болон тэдний гэр бүлийн сайн сайхан амьдралыг баталгаажуулсан олон улсын хүний эрхийн баримт бичиг болох Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн үндсэн зарчим юм.

1989 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг соёрхон баталсан билээ. Монгол улс уг Конвенцид 1990 онд нэгдэн орж, түүнийг хүлээн зөвшөөрсөн дэлхийн 5 дахь орон болсон юм.

Тус Конвенци нь 4 үндсэн зарчим дээр тулгуурладаг. Эхний 2 нь зөвхөн хүүхэд бус бүх хүмүүст үйлчилдэг бол удаахь 2 зарчим нь хүүхдэд тусгайлан үйлчлэх зорилготой юм.

- Хүүхэд өөрийнхөө яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсааны болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, эрүүл мэндийн байдал, төрсөн нөхцөл, эцэг эх юм уу хууль ёсны асран хамгаалагчдын байдал болон өөр нөхцөл байдлын улмаас ялгаварлан гадуурхагдах ёсгүй.
- Хүүхэд эсэн мэнд өсөн бойжих, хөгжих эрхийг амьдралын бүх талбарт эдлэнэ. Үүнд, бие бялдарын, сэтгэл санааны, нийгмийн сэтгэцийн, танин мэдэхүйн, нийгмийн болон соёлын зэрэг бүгд орно.
- Хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлыг шийдвэрлэхдээ эн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангахад анхаарна.
- Хүүхэд өөртэй нь холбоотой асуудлыг шийдвэрлэхэд биечлэн оролцох, өөрийнхөө саналыг илэрхийлэх эрхтэй. Хүүхдийн санаа бодлыг хүндэтгэн анхааран сонсож, асуудал шийдвэрлэхдээ бүрэн ач холбогдол өгөх ёстой.

Конвенцийн ерөнхий зарчмууд

Нэгдүгээр зүйл

18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ.

Хоёрдугаар зүйл

Хүүхэд бүр хүүхдийн болон түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн хийгээд бусад үзэл итгэл, үндэстний, үндэс угсааны буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрүүл мэндийн байдал, төрсөн газар болон өөр нөхцөл байдлыг үл харгалзан ямар нэг ялгаварлан гадуурхалтыг амсах ёсгүй.

Гуравдугаар зүйл

Хүүхдийн талаар аливаа үйл ажиллагаа явуулахдаа, хүүхдийн асуудлаар шийдвэр гаргахдаа улсын буюу хувийн байгууллага, шүүх, засаг захиргааны болон хууль тогтоох байгууллага, гэр бүлийн аль нь авч явуулж байгаа эсэхийг үл харгалзан эн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангахад анхаарлаа хандуулна.

Зургадугаар зүйл

Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, эрүүл саруул өсөж торних, бүхий л талаар хөгжих эрхтэй.

Арван хоёрдугаар зүйл

Хүүхдүүд өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, идэвхтэй оролцох эрхтэй бөгөөд хүүхдийн үзэл бодолд зохих анхаарал тавигдах ёстой.

Нийгмийн эрх ба хүүхдийн эрх чөлөө

Долдугаар зүйл

Хүүхэд бүр нэр авах, иргэний хаярлалтай болох эрх эдэлнэ

Наймдугаар зүйл

Хүүхэд бүр иргэний харьяалал, нэр авах болон гэр бүлийн холбоогоо хадгалах зэрэг хувийн онцлог байдлаа хэвээр байлгах, сэргээх эрхтэй

Арван гуравдугаар зүйл

Хүүхэд бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

Арван долдугаар зүйл

Хүүхэд бүр төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл олж авах эрхтэй.

Арван дөрөвдүгээр зүйл

Хүүхэд бүр чөлөөтэй бодож сэтгэх, сүсэглэх, шашин шүтлэгтэй байх эрхтэй.

Арван тавдугаар зүйл

Хүүхэд бүр эвсэл холбоо байгуулах, тайван замаар жагсаал цуглаан хийх эрхтэй.

Арван зургадугаар зүйл

Хүүхэд бүр хувийн нууцаа хадгалах эрхтэй

Хүүхдүүдийн болон тэдний гэр бүлийн эрх

Тавдугаар зүйл

Төр засаг нь эцэг эхчүүдийн болон гэр бүлийн хүүхдээ удирдан хөтлөх эрх, үүрэг, хариуцлагыг хүндэтгэнэ.

Арван наймдугаар зүйл, 1 ба 2 дугаар анги

Төр засаг нь хүүхдийн хүмүүжил, өсөлт бойжилтын талаар эцэг эх нь хамтдаа адил тэгш хариуцлага хүлээх зарчмыг хүлээн зөвшөөрөх явдлыг хангахын тулд боломжийнхоо хэрээр хүч чармайлт тавьж дэмжлэг үзүүлэх болно.

Ёсдүгээр зүйл

Хүүхэд бүр эцэг, эхтэйгээ амьдрах эрхтэй бөгөөд аль нэгнээс нь салж тусгаарлагдсан тохиолдолд эцэг эхийнхээ алинтай ч хувийн ба шууд харилцаатай байх эрхтэй.

Аравдугаар зүйл

Хүүхэд бүр эцэг эх, ам бүлтэйгээ нэгдэн нийлэх зорилгоор өөр улсад шилжин орох буюу түүнээс гарах эрхтэй.

Хорьдугаар зүйл

Өөрийн гэр бүлээсээ түр буюу бүр мөсөн хагацсан, эсвэл гэр бүлийнхээ дотор цаашдаа язгуур эрх ашигт нь харшлах аюултай болбол хүүхэд бүр асрамжлуулан хамгаалуулах, тусламж авах эрхтэй.

Хорин нэгдүгээр зүйл

Хүүхэд бүр язгуур эрх ашгийг нь харгалзсан аюулгүй үүрчлүүлэлтийн системд хамрагдах эрхтэй.

Хорин тавдугаар зүйл

Хүүхэд бүр өөртөө үзүүлж буй эмчилгээ болон асран хамгаалахтай холбогдсон бүх нөхцөлийн талаар тогтмол үнэлж цэгнэх эрхтэй.

Арван есдүгээр зүйл

Хүүхэд бүр эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон хүүхдийн төлөө анхаарал халамж тавих бусад хүмүүсийн зүгээс хүчирхийлэл, хайхрамжгүй харьцах зэрэг бүх хэлбэрээс хамгаалуулах эрхтэй. Хохирол үзсэн хүүхэд бүр бие бялдар болон сэтгэл санааны хувьд засал авахуулах, нийгмийн хэлхээ холбоогоо сэргээхэд нь дөхөм үзүүлэх шаардлагатай бүх арга хэмжээнд хамрагдах эрхтэй.

Эрүүл саруул, сайн сайхан байх хүүхдийн эрх

Хорин гуравдугаар зүйл

Тахир татуу, оюун санааны хомсдолтой хүүхэд бүр түүний нэр хүндийг хангахуйц нөхцөлд зохих ёсоор, төгс төгөлдөр аж төрөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрсөн, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох явдлыг хөнгөвчилсөн, өөртөө итгэлтэй байхад нь тус дэмтэй нөхцөлд асруулан хүмүүжих эрхтэй.

Хорин дөрөвдүгээр зүйл

Хүүхэд бүр эрүүлийг хамгаалах системийн хамгийн боловсронгуй үйлчилгээ, эрүүл мэндийг нөхөн сэргээх, өвчин анагаах орчин үеийн хэрэгслийг ашиглах эрхтэй.

Хорин зургадугаар зүйл, 1 ба 3-р анги

Хүүхэд бүр нийгмийн даатгалыг оролцуулан нийгэм хангамжаас хувь хүртэх эрхтэй.

Хорин долдугаар зүйл

Хүүхэд бүр өөрийнхөө бие бялдрын, оюун ухаан, ёс суртахууны болон нийгмийн хөгжлийг хангахуйц түвшинд амьдрах эрхтэй.

Хүүхдийн сурч боловсрох, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, соёлын амьдралд оролцох эрх

Хорин наймдугаар зүйл

Хүүхэд бүр анхан шатны боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй бөгөөд ерөнхий болон тусгай мэргэжлийн дунд боловсрол хүүхэд бүрт хүртээмжтэй байх ёстой.

Хорин ёсдүгээр зүйл

Хүүхэд бүр бие хүнийх нь хувьд болон түүний авьяас билэг, оюуны болон бие бялдрын авьяас чадварыг бүрэн төгс хөгжүүлэх боловсрол эзэмших эрхтэй. Тухайн боловсрол нь мөн чөлөөт нийгэмд идэвхтэй оролцох хүмүүжил олгосон; эцэг эх, улс орныхоо хэл, соёл, үнэт зүйлийг хүндэтгэх, байгаль орчноо хайрлан хамгаалах үзлээр хүмүүжүүлсэн, бие биенээ ойлгох, эвсэн найрамдал, хүлцэн тэвчих, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил тэгш байж, аливаа улс түмэн, янз бүрийн арьстан үндэстэн хийгээд шашны бүлгүүд, түүнчлэн уугуул нутгийн хүн ам өөр хоорондоо найрамдалтай байх үзлээр хүмүүжин ухамсартай амьдрах бэлтгэлийг хүүхдэд олгосон байх ёстой.

Гучин нэгдүгээр зүйл

Хүүхэд бүр амрах, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх, соёлын болон уран бүтээлийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй.

Тусгай хамгаалагдах эрх

Хорин хоёр, гучин найм ба гучин ёсдүгээр зүйл

Зэвсэг мөргөлдөөнд өртсөн, эцэг эх, гэр бүлээсээ салсан, эх орноосоо тусгаарлагдсан зэрэг онцгой нөхцөл байдалд хүүхэд бүр тусгайлан хамгаалагдах эрхтэй.

Дөчдүгээр зүйл, гучин долдугаар зүйлийн б, в, д ангилал

Хууль зөрчсөн тохиолдолд хүүхэд бүр тусгай хамгаалуулах эрхтэй.

Гучин хоёр, гучин гурав, гучин дөрөв ба гучин тавдугаар зүйлүүд

Хүүхэд бүр янз бүрийн мөлжлөгөөс тухайлбал, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөг, мансууруулах бодис хэрэглэх, бэлэгсийн харьцаа, садар самуунд уруу татах, хил давуулан дамлан наймаалах зэрэг бүхий л хэлбэрээс тусгай хамгаалуулах эрхтэй.

Гучдугаар зүйл

Үндэсний цөөнх буюу уугуул хүн амд харьяалагддаг хүүхдүүд үндэснийхээ соёлоо эзэмших, сүсэглэх, шашны үйл үйлдэх, төрөлх хэлээрээ ярих эрх эдэлнэ.

ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ КОНВЕНЦ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Нэгдүгээр зүйл

Энэхүү Конвенцийн зорилгын үүднээс авч үзвэл 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. Тэгэхдээ тухайн хүүхдийн талаар дагаж мөрддөг хуульд насанд хүрэх хугацааг үүнээс эрт байхаар авч үзээгүй бол тэгж үзнэ.

Хоёрдугаар зүйл

1. Оролцогч улсууд шүүн таслах эрх хэмжээнийхээ хүрээнд байгаа хүүхэд бүрт энэхүү Конвенцид заасан бүх эрхийг хүүхдийн болон түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн хийгээд бусад үзэл итгэл, үндэстний, үндэс угсааны буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрүүл мэндийн байдал, төрсөн газар болон өөр нөхцөл байдлыг үл харгалзан ямар нэг ялгаваргүйгээр хүндэтгэн хангана.
2. Оролцогч улсууд нь хүүхэд, түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон гэр бүлийн бусад гишүүдийн эрхийн байдал, үйл ажиллагаа, илэрхийлж байгаа үзэл бодол буюу итгэл үнэмшлийг иш үндэс болгон аливаа хэлбэрээр хүүхдийг ялгаварлан гадуурхах буюу шийтгэхээс хамгаалах шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Гуравдугаар зүйл

1. Хүүхдийн талаар аливаа ажил явуулахдаа түүнийг нийгэм хангамжийн асуудал эрхэлсэн улсын буюу хувийн байгууллага, шүүх, засаг захиргааны болон хууль тогтоох байгууллагын аль нь авч явуулж байгаа эсэхийг үл харгалзан, эн тэргүүнд хүүхдийн эрх ашгийг дээд зэргээр хангахад анхаарлаа хандуулна.
2. Оролцогч улсууд нь хууль ёсоор хүүхдийн төлөө хариуцлага хүлээх эцэг эх, асран хамгаалагч буюу бусад хүмүүсийн эрх үүргийг анхааралдаа аван, хүүхдийн аж байдлыг сайжруулахын тулд тэднийг зайлшгүй анхааран халамжлах үүрэг хүлээж, энэ зорилгоор хууль тогтоох болон захиргааны зохистой бүхий л арга хэмжээ авна.
3. Оролцогч улсууд хүүхдийг халамжлах, тэднийг хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагууд, тухайлбал эрүүлийг хамгаалах, аюулаас хамгаалах салбарт, тэдгээрийн ажилтны тоо, ажилд тэнцэх байдал, түүнчлэн үр нөлөөтэй хяналт тавих үүднээс эрх мэдэл бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд нийцэх тохирсон байхуйц нөхцөлөөр хангана.

Дөрөвдүгээр зүйл

Оролцогч улсууд энэхүү Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх хууль тогтоомж, захиргааны болон бусад арга хэмжээг авна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаар ийм арга хэмжээг оролцогч улсууд өөртөө байгаа нөөц бололцоог дээд зэргээр ашиглан, мөн шаардлагатай бол олон улсын хамтын ажиллагааны хүрээнд авна.

Тавдугаар зүйл

Оролцогч улсууд эцэг эхчүүдийн болон зохих тохиолдолд нутгийн ёс заншлын дагуу өргөтгөсөн гэр бүлийн буюу отог омгийн гишүүд, асран хамгаалагч болон хууль ёсоор хүүхдийн төлөө хариуцлага хүлээсэн бусад хүмүүсээс энэхүү Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхээ хэрэгжүүлэхийн тулд хүүхдийнхээ хөгжиж буй авьяас чадварын дагуу зохих ёсоор удирдан хөтлөх эрх, үүрэг, хариуцлагыг хүндэтгэнэ.

Зургадугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхэд бүрийн амьдрах салшгүй эрхийг хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд хүүхдийн амьд мэнд, эрүүл саруул өсөж торних нөхцөлийг аль болох дээд зэргээр хангана.

Долдугаар зүйл

1. Хүүхэд төрмөгцөө бүртгэгдэх ёстой бөгөөд төрсөн үеэсээ эхлэн нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн боломжийн хэрээр өөрийн эцэг эхийг мэдэх, мөн тэдний хайр халамжийг хүртэх эрх эдэлнэ.
2. Оролцогч улсууд эдгээр эрхийг үндэснийхээ хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж, энэ салбарт, тухайлбал, хүүхэд өөр харьяалалгүй байхаар байвал олон улсын зохих баримт бичгийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Наймдугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхэд иргэний харьяалалтай байх, нэр авах болон гэр бүлийн холбоогоо хадгалах зэргээр хувийн онцлог байдлаа хэвээр байлгах, хуульд заасан эрхийг нь хөндлөнгөөс хууль бусаар оролцох бололцоо олголгүйгээр хүндэтгэх үүрэг хүлээнэ.
2. Хэрвээ хүүхэд хувийн онцлог байдлаа зарим талаар буюу бүхэлд нь хууль бусаар алдахад хүрвэл оролцогч улсууд түүнд хувийн онцлог байдлаа нэн даруй сэргээхэд нь шаардагдах тусламж үзүүлж, хамгаална.

Ёсдүгээр зүйл

1. Оролцогч улсууд гагцхүү шүүхийн шийдвэрээр эрх мэдэл бүхий байгууллага дагаж мөрдөж байгаа хууль, журмынхаа дагуу хүүхдийн эрх ашигт бүрэн нийцүүлэх үүднээс зайлшгүй салгах шаардлагатай гэж үзсэнээс бусад бүх тохиолдолд хүүхдийг хүсэл санааг нь эс харгалзан эцэг эхээс нь салган өнчрүүлэхгүй байх нөхцөлийг хангана. Ингэж үзэх нь ямар нэг тодорхой тохиолдолд, жишээлбэл, эцэг эх нь хүүхэдтэйгээ хэрцгий догшин харьцдаг буюу анхаарч халамжилдаггүй, эсхүл эцэг эх нь тусдаа салангид амьдардгийг харгалзан тухайн хүүхдийн амьдрах газрын талаар шийдвэр зайлшгүй гаргах болсон үед шаардагдаж болох юм.
2. Энэхүү зүйлийн нэгдүгээрт заасны дагуу холбогдох аливаа асуудлыг хэлэлцэх сонирхогч бүх талыг оролцуулж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх бололцоог тэдгээрт олгоно.
3. Оролцогч улсууд хэрэв тухайн хүүхдийн язгуур эрх ашигт харшлахгүй бол эцэг эхийнхээ аль нэгнээс юм уу хоёулангаас нь салж өнчирсэн хүүхдийн эцэг эхийнхээ алинтай ч хувийн ба шууд харилцаатай байх эрхийг хүндэтгэнэ.
4. Ийм өнчрөл нь оролцогч улсуудын гаргасан ямар нэгэн шийдвэрээс, тухайлбал хүүхдийн эцэг эхийн аль нэг нь буюу хоёулаа, эсхүл хүүхэд нь баривчлагдсан, шоронд хоригдсон, тухайн нутгаасаа зайлуулагдсан, эх орноосоо хөөгдсөн буюу нас барсан (тухайн улсын мэдэлд байх хугацаанд ямар нэгэн шалтгааны улмаас нас барсан) зэргээс шалтгаалсан тохиолдолд оролцогч улсууд нь хэрэв хүүхдийн амьжиргааны байдалд хор уршиг учруулахгүй байвал эцэг эх, хүүхдэд буюу шаардлагатай бол өрхийн бусад гишүүдэд өөрсдийнх нь хүсэлтээр өрхийн эзгүй байгаа гишүүний (гишүүдийн) оршин суугаа газрын талаар шаардагдах мэдээлэл өгнө. Оролцогч улсууд ийм хүсэлт гаргах нь тухайн хүний (хүмүүсийн) хувьд тусгүй уршиг дагаварт хүргэхгүй байх нөхцөлийг цаашдаа хангана.

Аравдугаар зүйл

1. 9 дүгээр зүйлийн нэгдүгээрт заасны дагуу оролцогч улсууд үүргийнхээ ёсоор ам бүл нийлэх зорилгоор оролцогч улсад шилжин орох буюу түүнээс гарах тухай хүүхдийн болон түүний эцэг эхийн өргөдлийг нааштай, энэрэнгүй, шуурхай байдлаар авч үзвэл зохино. Ийм хүсэлт тавьсны учир өргөдөл гаргагч болон тэдний гэр бүлийн гишүүдийг цаашдаа аль нэг байдлаар хохироохгүй байх явдлыг оролцогч улсууд хангана.
2. Эцэг эх нь хоёр өөр улсад амьдарч байгаа бол онцгой шалтгаан байхгүй бол тухайн хүүхэд эцэг эхтэйгээ тогтмол хувийн болон шууд харилцаатай байх эрх эдэлнэ. Энэ зорилгоор мөн 9 дүгээр зүйлийн хоёрдугаарт заасны дагуу хүлээсэн үүргийнхээ дагуу оролцогч улсууд нь эх орноо буюу өөр аль ч улсыг орхин гарах, бас эх орондоо эргэж очих хүүхдийн болон түүний эцэг эхийн эрхийг хүндэтгэнэ. Аль ч орныг орхин гарах эрхийн хувьд л гагцхүү тухайн улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахын үүднээс хуульчлан тогтоосон, мөн энэхүү Конвенцид хүлээн зөвшөөрсөн бусад эрхтэй нийцсэн хязгаарлалт л байж болно.

Арван нэгдүгээр зүйл

1. Оролцогч улсууд хүүхдийг хууль бусаар гадаадаас шилжүүлэх юм уу буцаахгүй байх талаар арга хэмжээг авна.

2. Энэ зорилгоор оролцогч улсууд нь хоёр талын болон олон талын хэлэлцээр байгуулах буюу одоогийн дагаж мөрдөж байгаа хэлэлцээрт нэгдэн ороход тус дэмжлэг үзүүлнэ.

Арван хоёрдугаар зүйл

1. Оролцогч улсууд өөрийн гэсэн үзэл бодолтой байх чадвартай хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих анхаарал тавина.
2. Энэ зорилгоор өөртэй нь холбогдсон асуудал хэлэлцэж буй шүүхийн буюу захиргааны аль ч хурлын үйл ажиллагааны явцад биечлэн, эсхүл үндэсний хууль тогтоомжийн байцаан шийтгэх хэм хэмжээгээр тогтоосон журмын дагуу төлөөлөгчөөр болон зохих байгууллагаар дамжуулан үг хэлэх бололцоог хүүхдэд олгоно.

Арван гуравдугаар зүйл

1. Хүүхэд нь санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрх нь хил хязгаараас үл шалтгаалан амаар, бичгээр болон хэвлэлээр мөн урлагийн бүтээлийн хэлбэрээр буюу хүүхдийн сонгосон бусад арга хэрэгслийн тусламжтайгаар аливаа төрлийн мэдээлэл, үзэл санааг эрж хайх, олж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөөг өөртөө багтаана.
2. Энэ эрхийг хэрэгжүүлэхэд зарим хязгаарлалт байж болох бөгөөд гэхдээ энэ хязгаарлалт нь гагцхүү хуульд заагдсан байхын дээр:
 - а) бусдын эрх болон нэр алдрыг хүндэтгэхэд
 - б) улсын аюулгүй байдал болон нийгмийн хэв журам, эсхүл хүн ардын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байвал зохино.

Арван дөрөвдүгээр зүйл

1. Оролцогч улсууд нь чөлөөтэй бодох сэтгэх, сүсэглэх, шашин шүтлэгтэй байх хүүхдийн эрхийг хүндэтгэнэ.
2. Оролцогч улсууд нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхдээ түүний хөгжиж буй авьяас чадварт тохирох аргаар удирдах эцэг эхийн хийгээд зохих нөхцөлд хууль ёсны асран хамгаалагчийн эрх, үүргийг хүндэтгэнэ.
3. Шашин шүтэх буюу сүсэглэх эрх чөлөө нь гагцхүү улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн ардын ёс суртахуун, эрүүл мэндийг болон бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс хуулиар тогтоосон хязгаарлалттай байж болно.

Арван тавдугаар зүйл

1. Оролцогч улсууд эвсэл холбоо байгуулах, тайван замаар жагсаал цуглаан хийх хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө.
2. Энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд гагцхүү хуулийн дагуу хэрэглэгдэх, ардчилсан нийгэм дэх улсын болон нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу хэрэгжүүлэх хязгаарлалтаас өөр ямар ч хязгаарлалт байж болохгүй.

Арван зургадугаар зүйл

1. Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс хууль бусаар буюу дур зоргоороо оролцох, орон байрны халдашгүй байдлыг зөрчих, захидал харилцааны нь нууцыг алдагдуулах, эсхүл түүний нэр төр, нэр алдрыг хууль бусаар гутаах ёсгүй.
2. Хүүхэд нь тэгж хөндлөнгөөс оролцох гэх юм уу, нэр төрийг нь гутаах гэвэл хуулиар хамгаалуулах эрхтэй.

Арван долдугаар зүйл

Оролцогч улсууд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн чухал үүрэг ролийг хүлээн зөвшөөрч, хүүхэд нь олон улсын болон үндэсний аливаа эх сурвалжаас мэдээлэл, материал, ялангуяа хүүхдийн

нийгмийн, оюуны болон ёс суртахууны таатай нөхцөл бүрдүүлэх, түүнчлэн бие бялдар, сэтгэл санааны хувьд эрүүл чийрэг өсөн бойжиход нь тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн мэдээлэл, материал олж авах боломжийг хангана. Энэ зорилгоор оролцогч улсууд:

а) олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийгмийн болон соёлын талаар хүүхдэд ашигтай, мөн 29 дүгээр зүйлийн үзэл санааг агуулсан мэдээлэл, материал түгээн дэлгэрүүлэхийг хөхүүлэн дэмжинэ,

б) соёлын, үндэсний болон олон улсын аливаа эх сурвалжаас ийм мэдээлэл, материалыг бэлтгэн боловсруулах, солилцох, түгээн дэлгэрүүлэх талаарх олон улсын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжинэ,

в) хүүхдийн уран зохиолыг хэвлэн нийтлэх, түгээн дэлгэрүүлэхийг хөхүүлэн дэмжинэ,

г) аль нэг цөөнх хэсэгт буюу уугуул хүн амд хамаарах хүүхдийн хэлний эрэлт хэрэгцээнд олон нийтийн мэдээллийн хэрэгслээс онцгойлон анхаарахыг хөхүүлэн дэмжинэ.

д) 13, 18 дугаар зүйлүүдийн заалтыг харгалзан хүүхдийн сайн сайхан байдалд хор хохирол учруулж болзошгүй мэдээлэл, материалаас түүнийг хамгаалах зохих зарчмуудыг боловсруулах явдлыг хөхүүлэн дэмжинэ.

Арван наймдугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхдийн хүмүүжил, өсөлт бойжилтын талаар эцэг эх нь хамтдаа адил тэгш хариуцлага хүлээх зарчмыг хүлээн зөвшөөрөх явдлыг хангахын тулд боломжийнхоо хэрээр хүч чармайлт тавина. Эцэг эх буюу зохих тохиолдолд зөвшөөрөгдсөн хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийн хүмүүжил, өсөлт бойжилтын талаар гол хариуцлагыг хүлээнэ. Хүүхдийн эрхэм дээд эрх ашиг нь тэдний анхааран халамжлах гол зүйл мөн.
2. Энэхүү Конвенцид дурдсан эрхийг хэрэгжүүлэхэд тус дэмжлэг үзүүлэх, баталгаатай болгохын тулд оролцогч улсууд хүүхдээ хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхэд нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч нарт шаардлагатай тусламж үзүүлэх бөгөөд хүүхдийн байгууллагыг хөгжүүлэх явдлыг хангана.
3. Эцэг эх нь ажил эрхэлдэг хүүхдүүд зориулагдсан асрах алба, газруудад өсч бойжих эрхээ эдлэхэд нь оролцогч улсууд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

Арван есдүгээр зүйл

1. Оролцогч улсууд нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон хүүхдийн төлөө анхаарал халамж тавих бусад хүмүүсийн зүгээс бие бялдар, сэтгэл санааны талаар хүчирхийлэх, доромжлох буюу үүргээ хортойгоор ашиглах, анхаарч халамжлахгүй байх буюу хайхрамжгүй харьцах, бүдүүлэг авирлах, мөлжих, үүний дотор бэлэгсийн харилцаанд ашиглах зэрэг бүх хэлбэрээс хүүхдийг хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны нийгмийн болон гэрээрийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.
2. Хамгаалалтын энэхүү арга хэмжээнүүд нь хэрэв шаардлагатай бол хүүхдэд болон тэднийг халамжилдаг хүмүүст зайлшгүй чухал тус дэмжлэг үзүүлэх зорилгоор, түүнчлэн дээр дурдсанчлан хүүхэдтэй хэрцгий догшин харьцсан тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, шаардлагатай арга хэмжээ авах, эмчлүүлэх, мөрдөн байцаах, хэлэлцүүлэхээр шилжүүлэх болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн шаардлагатай бол хэрэг үүсгэхийн тулд нийгмийн тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх үр ашигтай журам горимыг багтаана.

Хорьдугаар зүйл

1. Өөрийн гэр бүлээсээ түр буюу бүр мөсөн хагацсан, эсвэл гэр бүлийнхээ дотор цаашдаа язгуур эрх ашигт нь нь харшлах аюултай болбол тухайн хүүхэд улсаас онцгойлон асрамжлуулан хамгаалуулах, тусламж авах эрхтэй.
2. Оролцогч улсууд нь өөрсдийн үндэсний хуулиудын дагуу ийм хүүхдийг гэр бүлээс нь өөр нөхцөлд асрах бололцоог хангана.
3. Ингэж амрамжлах явдалд, тухайлбал, хүүхдийг хүмүүжүүлэх зорилгоор шилжүүлэх, лалын шашны эрх зүйн дагуу “кафала” хэрэглэх, үрчлүүлэх буюу шаардлагатай тохиолдолд хүүхдийн асрамжийн зохих газарт байлгах зэрэг зүйл хамаарч болно. Хүүхдийн асрамжийг шийдвэрлэх хувилбарыг авч үзэхдээ хүүхдийн хүмүүжлийн залгамж чанарыг эрхэмлэхийн дээр гарал угсаа, сүсэг бишрэлийн болон соёлын хамаарал, эх хэлийг нь зохих ёсоор харгалзан үзэх ёстой.

Хорин нэгдүгээр зүйл

1. Үрчлэлтийн систем байхыг хүлээн зөвшөөрч байгаа оролцогч улсууд нь хүүхдийн язгуур эрх ашгийг эн тэргүүнд харгалзах явдлыг хангах бөгөөд тэдгээр нь:

а. энэ хэрэгт хамаарагдах бүх үнэн зөв мэдээллийн үндсэн дээр эцэг эх, хамаатан садан, хууль ёсны асран хүмүүжүүлэгч нарын тухайд хүүхдийн эрхийн байдлыг харгалзсан дээр шаардлагатай тохиолдолд зөвлөлдөөний үндсэн дээр сонирхогч этгээдээс үрчлүүлэх тухай зөвшөөрлийг ухамсарлан өгсөн тохиолдолд дагаж мөрдөж байгаа хууль, журмын дагуу үрчлэх боломжтойг тодорхойлсон гагцхүү эрх мэдэл бүхий засгийн эрх барих байгууллагаар хүүхэд үрчлэхийг зөвшөөрсөн байх явдлыг хангана,

б. хэрэв хүүхдийн хүмүүжил буюу үрчлэлтийг хангаж чадахуйц гэр бүлд байлгах буюу хүмүүжүүлэх зорилгоор шилжүүлэх, эсхүл тухайн хүүхдийн төрсөн оронд зохих ёсоор нь асрамжлах боломжгүй гэж үзвэл, өөр оронд үрчлүүлэх нь хүүхдийг асарч хамгаалах боломжтой арга хэмжээ хэмээн авч үзэхийг хүлээн зөвшөөрнө,

в. хүүхдийг өөр оронд үрчлүүлэх тохиолдолд, үрчлэлтийн талаар дагаж мөрддөг хэм хэмжээ, баталгааг тухайн оронд дагаж мөрддөгтэй адил хэмжээнд хэрэглэх явдлыг хангана,

г. хүүхдийг бусад оронд үрчлүүлэх тохиолдолд, түүнийг төвхнүүлэн суурьшуулах явдал нь үүнтэй холбоотой хүмүүст эдийн засгийн зүй бус ашиг хонжоо олоход хүргэхгүй байхыг хангахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна,

д. энэхүү зүйлийн зорилгыг хангахын тулд, хэрэв шаардлагатай бол, хоёр талын буюу олон талын тохиролцоо буюу хэлэлцээр байгуулахад тус дэмжлэг үзүүлж, энэ үндсэн дээр хүүхдийг өөр оронд төвхнүүлэн суурьшуулах асуудлыг эрх мэдэл бүхий засаг төрийн эрх барих байгууллага шийдвэрлэх явдлыг хангахыг эрмэлзэнэ.

Хорин хоёрдугаар зүйл

1. Оролцогч улсууд нь эцэг эх болон бусад хүмүүс дагалдсан эсэхийг үл харгалзан дүрвэгчийн эрх олж авахыг хүссэн буюу дагаж мөрдөж байгаа олон улсын болон дотоодын эрх зүй, ёс журмын дагуу дүрвэгч хэмээн тооцогдох хүүхдэд энэхүү Конвенц болон тухайн орны оролцсон хүний эрхийн талаарх буюу хүмүүнлэг ёсны олон улсын баримт бичигт дурдагдсан эрхээ эдлэхэд нь зохих ёсоор хамгаалж, энэрэнгүй тусламж үзүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авна.
2. Энэ зорилгоор оролцогч улсууд нь дүрвэгч хүүхдийг хамгаалах, тусламж үзүүлэх, мөн түүнийг гэр бүлийнхэнтэйгээ нэгдэн нийлэхэд шаардагдах бүх мэдээллийг олж авахаар уг хүүхдийн эцэг эх буюу гэр бүлийн бусад гишүүдийг эрэн сурвалжлах талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран ажилладаг бусад эрх мэдэл бүхий засгийн газар хоорондын буюу засгийн газрын бус байгууллагын аливаа хүч чармайлтад шаардлагатай гэж үзвэл тус дэмжлэг үзүүлнэ. Эцэг эх буюу гэр бүлийн бусад гишүүд нь олдохгүй байгаа тохиолдолд уг хүүхдийн хамгаалах эрхийг энэхүү Конвенцид заасан ёсоор аливаа шалтгааны улмаас өөрийн гэр бүлээс бүрмөсөн буюу түр хагацсан хүүхдийг хамгаалах эрхтэй адил хэмжээнд эдлүүлнэ.

Хорин гуравдугаар зүйл

1. Оролцогч улсууд тахир дутуу, оюун санааны хомсдолтой хүүхэд нь түүний нэр хүндийг хангахуйц нөхцөлд зохих ёсоор, төгс төгөлдөр аж төрөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч нийгмийн амьдралд идэвхтэй оролцох явдлыг хөнгөвчлөн, өөртөө итгэлтэй байхад нь тус дэмжлэг үзүүлнэ.
2. Оролцогч улсууд нь хомсдолтой хүүхэд онцгой халамж эдлэх эрхтэйг хүлээн зөвшөөрч хүүхдийн болон түүний эцэг эх, халамжлагч бусад хүмүүсийн байдалтай нийцэж байвал энэ эрхийг эдлэгч хүүхэд болон түүний төлөө анхаарал халамж тавигчдад гаргасан хүсэлтийнх нь дагуу байгаа нөөц бололцооныхоо хэрээр тусламж үзүүлэхийг хөхүүлэн дэмжиж хангана.
3. Энэ зүйлийн хоёрдугаарт заасны дагуу хомсдолтой хүүхдийн онцгой хэрэгцээнд нийцүүлэн, эцэг эх буюу хүүхдийн төлөө анхаарал халамж тавигч бусад хүмүүсийн санхүүгийн нөөц бололцоог харгалзан аль болохоор үнэ төлбөргүй тусламж үзүүлэх бөгөөд энэ тусламж нь хүүхдийн соёлын болон оюун санааны хөгжлийг оролцуулан бололцооны хирээр бие хүний хувьд хөгжлийг нь бүрэн дүүрэн хангах, нийгмийн амьдралд түүнийг татан оролцуулахад чиглэсэн боловсрол мэргэжлийн бэлтгэл, эмнэлгийн үйлчилгээ, эрүүл мэндээ нөхөн сэргээх, хөдөлмөрийн үйл

ажиллагаанд бэлтгэх, амрах бололцоогоор хангагдах зэрэг үйлчилгээг үр нөлөөтэй хэрэглэх боломжоор хангахыг зорино.

4. Оролцогч улсууд нь нөхөн сэргээх арга, ерөнхий боловсролын болон мэргэжлийн бэлтгэлийн талаар мэдээлэл түгээн дэлгэрүүлэх зэргээр хомсдолтой хүүхдийг сэргийлэх эмчилгээ, сэтгэл зүйн болон функц эмчилгээний салбарт өөрийн мэдлэг туршлагыг өргөжүүлэх, өөрсдийн бололцоог дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлэхийн тулд энэ салбарт олон улсын хамтын ажиллагааны үзэл санаагаар зохих мэдээлэл солилцох, ийм мэдээллээр хангагдах явдалд тус дөхөм үзүүлнэ. Үүнтэй холбогдуулан хөгжиж буй орнуудын эрэлт хэрэгцээнд онцгой анхаарал хандуулбал зохино.

Хорин дөрөвдүгээр зүйл

1. Оролцогч улсууд эрүүлийг хамгаалах системийн хамгийн боловсронгуй үйлчилгээ, эрүүл мэндийг нөхөн сэргээх, өвчин анагаах орчин үеийн хэрэгслийг ашиглах хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд эрүүлийг хамгаалах системийн ийм үйлчилгээ хэрэглэх эрхээ нэг ч хүүхэд хасуулахгүй байх бололцоогоор хангахыг эрмэлзэнэ.

2. Оролцогч улсууд энэхүү эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг чармайх бөгөөд тухайлбал:

а. Нялхсын болон хүүхдийн эндэгдлийн төвшинг бууруулах

б. эн тэргүүнд анхан шатны эмнэлэг - ариун цэврийн тусламжийг өргөжүүлэхэд анхаарлаа хандуулан бүх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламжийг үзүүлэх,

в. хүрээлэн байгаа орчин бохирдох аюул тулгарч байгааг анхааралдаа авч, анхан шатны эмнэлэг - ариун цэврийн тусламжийн хүрээнд ундны цэвэр ус, зохих тэжээллэг хоол хүнсээр хангах, мөн хөнгөн хялбар технологи хэрэглэх замаар өвчин эмгэг, өлмөн ээлмэн байдалтай тэмцэх,

г. төрөхийн өмнө болон төрсний дараа эрүүл мэндээ хамгаалуулах зохистой үйлчилгээгээр эхчүүдийг хангах,

д. хүүхдийн эрүүл мэнд, хоол, тэжээл, хөхнийхээ сүүгээр тэжээхийн давуу тал, эрүүл ахуй, хүүхдийн амьдрах орчны ариун цэврийн тухай, золгүй явдлаас урьдчилан сэргийлэх тухай мэдээллээр нийгмийн бүх давхарга, тухайлбал, эцэг эх, хүүхдүүдийг хангах, түүнчлэн боловсрол эзэмших, олсон мэдлэгээ ашиглахад дэмжлэг тусалцааг үзүүлэх,

е. өрхийн гишүүдийн тоог төлөвлөх болон урьдчилан сэргийлэх эмнэлгийн тусламжийн талаарх гэгээрүүлэх ажил, үйлчилгээг хөгжүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээ авна.

3. Оролцогч улсууд хүүхдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж болзошгүй уламжлалт практикийг арилгах зорилгоор аливаа үр ашигтай, зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авна.

4. Оролцогч улсууд энэ зүйлд хүлээн зөвшөөрсөн эрхийг аажмаар бүрэн хэрэгжүүлэх зорилгоор олон улсын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж, хөгжүүлэх үүрэг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан хөгжиж буй орнуудын эрэлт хэрэгцээнд онцгой анхаарал тавилбал зохино.

Хорин тавдугаар зүйл

Оролцогч улсууд асран хамгаалах, бие бялдарын болон сэтгэл зүйн эмчилгээ хийх зорилгоор эрх мэдэл бүхий байгууллагын шийдвэрээр асрамжинд авсан хүүхэд өөртөө үзүүлж буй эмчилгээ болон асран хамгаалахтай холбогдсон бусад бүх нөхцөлийн талаар тогтмол үнэлж цэгнэх эрхтэйг хүлээн зөвшөөрнө.

Хорин зургадугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхэд бүр нийгмийн даатгалыг оролцуулан нийгэм хангамжаас хүртэх эрхтэйг хүлээн зөвшөөрч, энэ эрхээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу авна.

2. Хүүхдийн өөрийн болон түүнийг тэжээн тэтгэх үүрэг бүхий хүмүүсийн нөөц бололцоог хийгээд хүүхэд өөрөө буюу түүний нэрийн өмнөөс нийгэм хангамжаас хувь хүртэхтэй холбоотой аливаа асуудлыг харгалзан нийгэм хангамжаас шаардлагын хэрээр хувь хүртээнэ.

Хорин долдугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхэд бүр өөрийнхөө бие бялдрын, оюун ухааны, оюуны, ёс суртахууны болон нийгмийн хөгжлийг хангахуйц түвшинд амьдрах эрхтэйг хүлээн зөвшөөрнө.
2. Эцэг эх буюу хүүхдийг хүмүүжүүлж байгаа хүмүүс хүүхдийн өсөлт бойжилтод шаардагдахуйц амьдралын нөхцөлийг өөрийн авьяас чадвар, санхүүгийн боломжийнхоо хэрээр хангах явдлыг үндсэнд нь хариуцна.
3. Оролцогч улсууд үндэснийхээ нөхцөлийг харгалзан, өөрийн боломжийн хүрээнд эцэг эх хийгээд хүүхдийг хүмүүжүүлж байгаа бусад хүмүүсээс энэ эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээ авч туслахын сацуу шаардагдсан нөхцөлд материалын тусламж үзүүлж, ялангуяа хүнс тэжээл, хувцас хунар, орон сууцаар хангахад чиглэсэн программыг дэмжинэ.
4. Оролцогч улсууд хүүхдийн эцэг эх болон түүний талаар санхүүгийн хариуцлага хүлээх бусад хүмүүс хүүхдийг улсын дотоодод төдийгүй хилийн чанадаас тэжээн тэтгэх явдлыг сэргээхэд чиглэсэн бүхий л шаардлагатай арга хэмжээг авна. Тухайлбал, хүүхэд болон түүний талаар санхүүгийн хариуцлага хүлээх хүн өөр өөр улсад оршин суудаг бол оролцогч улсууд олон улсын хэлэлцээрт нэгдэн орох буюу ийм хэлэлцээр байгуулах, түүнчлэн бусад зохих тохиролцоонд хүрэхэд дөхөм үзүүлнэ.

Хорин наймдугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхдийн сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, адил тэгш боломжийн үндсэн дээр энэ эрхийг аажмаар хэрэгжүүлэхийн тулд доорхи арга хэмжээг авна. Үүнд:
 - а. заавал эзэмших анхан шатны боловсролыг үнэ төлбөргүй олгоно,
 - б. ерөнхий болон тусгай мэргэжлийн дунд боловсролын янз бүрийн хэлбэрийг хөгжүүлэх явдлыг хөхүүлэн дэмжиж, уг боловсролыг бүх хүүхдэд хүртээмжтэй болгож, үнэ төлбөргүй эзэмшүүлэх, шаардлагатай үед санхүүгийн тусламж үзүүлэх зэрэг шаардагдах арга хэмжээ авна,
 - в. хүн бүрт өөрийн авьяас чадварт түшиглэн дээд боловсрол эзэмших бололцоог шаардлагатай бүх хэрэгслийн тусламжтайгаар хангана,
 - г. боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгох салбарын мэдээлэл, материалыг бүх хүүхдэд хүртээмжтэй болгоно.
 - д. хүүхдийг хичээлд нь тогтмол суулгах болон сургуулиас завсардсан сурагчдын тоог цөөрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авна.
2. Оролцогч улсууд энэхүү Конвенцийн дагуу, хүүхдийн нэр хүндийг хүндэтгэхэд чиглэсэн аргаар сургуулийн сахилгыг сахиулахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг авна.
3. Оролцогч улсууд боловсрол олгохтой холбогдсон асуудлаарх, тухайлбал, дэлхий дахинд бичиг үсэг үл мэдэх, харанхуй бүдүүшлэг явдлыг арилгахад тус дөхөм үзүүлэх, шинжлэх ухаан-техникийн мэдлэг болон сургалтын орчин үеийн аргыг эзэмших бололцоог хөнгөвчлөхөд чиглэсэн олон улсын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж, хөгжүүлнэ. Үүнтэй холбогдуулан хөгжиж буй орнуудын эрэлт хэрэгцээнд онцгой анхаарал тавибал зохино.

Хорин ёсдүгээр зүйл

1. Оролцогч улсууд хүүхдэд олгох боловсрол дараах зүйлд чиглэх ёстойг тохиролцож байна. Үүнд:
 - а. хүүхдийг бие хүнийх нь хувьд болон түүний авьяас билэг, оюуны болон бие бялдрын авьяас чадварыг бүрэн төгс хөгжүүлэх,
 - б. хүний эрх, үндсэн эрх чөлөө, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмыг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх,
 - в. хүүхдийн эцэг эх, оршин сууж буй улс орны хийгээд өөрийн нь төрсөн улс орны өвөрмөц соёл, хэл, үнэт зүйл, үндэсний үнэт зүйл болон өөрийнхөөс нь ялгаатай соёл иргэншлийг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх,
 - г. чөлөөт нийгэмд бие биенээ ойлгох, эвсэн найрамдал, хүлцэн тэвчих, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд адил тэгш байж, аливаа улс түмэн, янз бүрийн арьстан үндэстэн хийгээд шашны бүлгүүд, түүнчлэн уугуул

нутгийн хүн ам өөр хоорондоо найрамдалтай байх үзлээр хүмүүжин ухамсартай амьдрах бэлтгэлийг хүүхдэд олгох,

д. байгаль орныг хайрлан хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэхэд чиглэнэ.

2. Энэ зүйл болон 28 дугаар зүйлийн аль ч хэсэг нь хувь хүмүүс хийгээд байгууллагууд энэ зүйлийн нэгдүгээрт заасан зарчмыг байнга сахиж, олгож байгаа боловсрол нь төрөөс тогтоож болох наад захын хэм хэмжээнд нийцэж байгаа нөхцөлд сургууль байгуулж, түүнийгээ удирдах эрх чөлөөг хязгаарласан байдлаар тайлбарлаж болохгүй.

Гучдугаар зүйл

Яс угсаа, шашин шүтлэг, хэл ярианы хувьд цөөнх байдаг эсхүл уугуул нутгийн хүн ам оршин суудаг улсуудад ийм цөөнх буюу уугуул хүн амд харьяалагддаг хүүхэд өөрийн бүлгийн гишүүдтэй хамтран соёлоо эзэмших, сүсэглэх, шашны зан үйл үйлдэх, түүнчлэн төрөлх хэлээрээ ярих эрхээ эдлэхэд хэрхэвч хориг саад тавьж болохгүй.

Гучин нэгдүгээр зүйл

1. Оролцогч улсууд хүүхдийн амрах, чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх насныхаа байдалд тохирсон тоглоом, наадамд оролцох, соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагаар хичээллэх эрхийг хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд нь хүүхдийн соёлын болон уран бүтээлийн амьдралд бүх талаар оролцох эрхийг хүндэтгэн хөхүүлэн дэмжиж, соёлын болон уран бүтээлийн үйл ажиллагаанд оролцох, чөлөөт цаг болон амралтаа эдлэхэд зохистой бөгөөд адил тэгш бололцоо олгоход дөхөм үзүүлнэ.

Гучин хоёрдугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхэд бол эдийн засгийн мөлжлөгөөс болон түүний эрүүл мэндэд хор аюул учруулах буюу боловсрол олоход нь саад болох, эсхүл түүний эрүүл мэндэд болон бие бялдрын, оюун ухааны, оюуны, ёс суртахууны хийгээд нийгмийн хөгжилд хор уршиг учруулж болзошгүй аливаа ажил эрхлэх явдлаас хамгаалагдах эрхтэйг хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд энэ зүйлийг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоомжийн, захиргааны, нийгмийн арга хэмжээ, түүнчлэн боловсролын салбарт зохих арга хэмжээ авна. Энэ зорилгоор оролцогч улсууд олон улсын бусад баримт бичгийн холбогдох заалтуудыг удирдлага болгон, тухайлбал:

а. ажилд авах насны доод хязгаарыг тогтооно,

б. ажлын өдрийн үргэлжлэх хугацаа болон хөдөлмөрийн нөхцөлийн талаарх зайлшгүй шаардлагыг тодорхойлно.

в. энэ зүйлийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс шийтгэлийн зохих төрлүүдийг буюу нөлөөллийн бусад арга хэмжээг урьдчилж тогтооно.

Гучин гуравдугаар зүйл

Оролцогч улсууд олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсон мансууруулах бодис болон сэтгэл мэдрэлд хүчтэй үйлчилэх бодисыг хууль бусаар хэрэглэх явдлаас хүүхдийг хамгаалах, эдгээр бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулахад хүүхдийг ашиглах явдал гаргуулахгүйн тулд хууль тогтоомжийн, захиргааны, нийгмийн шаардлагатай бүх арга хэмжээ, түүнчлэн боловсролын салбарт зохих арга хэмжээ авна.

Гучин дөрөвдүгээр зүйл

Оролцогч улсууд хүүхдийг мөлжлөгийн зорилгоор бэлэгсийн харьцаа, садар самуунд уруу татах бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дор дурдсан зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг үндэстний, хоёр талын болон олон талын хэмжээнд авна. Үүнд:

а. хүүхдийг бэлэгсийн хууль бус аливаа ажиллагаанд татан оруулах буюу албадах,

б. хүүхдийг мөлжлөгийн зорилгоор биеэ худалдах буюу бэлэгсийн хууль бус бусад хэрэгт ашиглах,

в. хүүхдийг мөлжлөгийн зорилгоор садар самууны зүйлд болон садар самуун явдлыг дүрсэлсэн материалд ашиглахаас урьдчилан сэргийлнэ.

Гучин тавдугаар зүйл

Оролцогч улсууд хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр хулгайлах, худалдах буюу тэднийг худалдах зорилгоор хууль бусаар хил нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн шаардлагатай бүх арга хэмжээг үндэстний, хоёр талын болон олон талын хэмжээнд авна.

Гучин зургадугаар зүйл

Оролцогч улсууд хүүхдийн аж байдалд ямар нэг хор уршиг учруулж болзошгүй мөлжлөгийн бусад бүхийл хэлбэрээс хүүхдийг хамгаална.

Гучин долдугаар зүйл

Оролцогч улсууд:

а. нэг ч хүүхдийг тамлан зовоож, хэрцгий харгислаж, хүний ёсноос гадуур харьцаж, эсхүл нэр хүндийг нь гутааж юм уу шийтгэхгүй байх, 18 насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэгт цаазаар авах буюу ямар ч хөнгөлөлтгүйгээр бүх насаар нь гянданд хорих ял оногдуулахгүй байх,

б. нэг ч хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур зоргоор хасаж болохгүй. Хүүхдийг баривчлах, албадан саатуулах, гянданд хорих ядлыг хуулийн дагуу гүйцэтгэх бөгөөд гагцхүү эцсийн арга хэмжээ болгож, аль болохуйц богино хугацаагаар хэрэглэх,

в. эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүртэй түүний насны хүмүүсийн эрэлт хэрэгцээг харгалзах үндсэн дээр хүнлэг ёсоор харьцаж түүний салшгүй нэр хүндийг нь хүндэтгэнэ. Тухайлбал, эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр, түүний язгуур эрх ашгийн үүднээс болохгүй гэж үзээгүй л бол насанд хүрэгчдээс тусгаарлагдсан байх ёстой бөгөөд онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд ар гэрийнхэнтэйгээ захидлаар харьцах, уулзах зэргээр холбоотой байх эрх,

г. эрх чөлөөгөө хасуулсан хүүхэд бүр эрх зүйн болон бусад зохих тусламжийг даруй авах эрх эдлэх, түүнчлэн эрх чөлөөгөө хасуулсан нь хууль ёсонд хэр зэрэг нийцэж байгааг тогтоолгохын тулд хүүхэд буюу бусдын нөлөөнд автагдаагүй, хараат бус, эрх бүхий байгууллагад мэтгэлзэх хийгээд байцаан шийтгэх аливаа ийм ажиллагааны талаар шийдвэрийг даруй гаргуулах эрхийг хангана.

Гучин наймдугаар зүйл

1. Оролцогч улсууд зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд хүүхдүүдэд хамаарах бөгөөд тэдэнд хэрэглэж болох олон улсын хүмүүнлэг эрхийн хэм хэмжээг хүндэтгэн үзэж сахин биелүүлэх үүргийг хүлээнэ.
2. Оролцогч улсууд 15 нас хүрээгүй хүүхдийг байлдааны ажиллагаанд биечлэн оролцуулахгүй байх явдлыг хангахад чиглэсэн бололцоотой бүх арга хэмжээг авна.
3. Оролцогч улсууд 15 насанд хүрээгүй хэнийг ч өөрийн зэвсэгт хүчинд алба хаалгахаар татахаас түдгэлзэнэ. Нэгэнт 15 насанд хүрсэн боловч 18 насанд хараахан хүрээгүй хүнийг цэрэгт татахдаа насаар арай ахмадыг нь татахыг урьдал болгохыг эрмэлзэнэ.
4. Зэвсэгт мөргөлдөөний үеэр энгийн ард иргэдийг хамгаалахтай холбогдсон олон улсын хүмүүнлэг эрх зүйн дагуу хүлээсэн үүрэг ёсоороо оролцогч улсууд зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүүхдүүдийг хамгаалж, тэднийг арчлан хамгаалах явдлыг хангах зорилгоор бололцоотой бүх арга хэмжээг авах үүрэг хүлээнэ.

Гучин есдүгээр зүйл

Оролцогч улсууд аливаа хайхрамжгүй харьцсан, дарлан мөлжсөн буюу үүргээ хортойгоор ашигласан, тарчлаан зовоосон буюу өөр хэрцгий, хүний ёсноос гадуур харьцсаны буюу нэр хүндийг нь гутаасан, шийтгэсэн, эсхүл зэвсэгт мөргөлдөөнд өртөж хохирол үзсэн хүүхдийг бие бялдар болон сэтгэл санааны хувьд засал авахуулах, нийгмийн хэлхээ холбоогоо сэргээхэд нь дөхөм үзүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү засал олох, хэлхээ холбоогоо сэргээх явдал нь хүүхдийн эрүүл мэнд, нэр хүнд, өөрийгөө хүндэтгэн үзэх үзлийг хангахуйц нөхцөлд хэрэгжих ёстой.

Дөчдүгээр зүйл

1. Оролцогч улсууд эрүүгийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж яллагдан гэм буруутайд тооцогдсон хүүхдэд өөрийнхөө нэр алдар, үнэ цэнээ мэдрэх, хүний эрх, бусдын үндсэн эрх чөлөөг хүндэтгэн үзэх үзлийг бататгахад дөхөм үзүүлэх, ингэхдээ түүний насны онцлог болон хэлхээ холбоогоо сэргээх, нийгэмд ашигтай үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхүйцээр харьцахыг шаардах эрхтэйг хүлээн зөвшөөрнө.
2. Энэ зорилгоор олон улсын баримт бичгийн холбогдох заалтыг анхааралдаа авч, оролцогч улсууд доорхи зүйлийг хангана. Тухайлбал:
 - a. гэмт хэрэгт холбогдох үедээ үндэсний хууль буюу олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хориглогдоогүй байсан тийм үйлдэл хийсэн буюу хийгээгүй гэсэн шалтгаанаар нэг ч хүүхдийг эрүүгийн хууль зөрчсөн гэж яллаж, гэм буруутайд тооцохгүй байх,
 - б. эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн гэж тооцогдсон буюу яллагдаж байгаа хүүхэд бүрт наад захын дараахь баталгаат эрхийг эдлүүлэх. Үүнд:
 - I. Гэм буруутай нь хуулийн дагуу тогтоогдох хүртэл түүнийг гэм буруугүйд тооцох,
 - II. Түүнд ногдуулж байгаа ялыг өөрт нь буюу шаардлагатай тохиолдолд эцэг эх, түүний хууль ёсны асран хамгаалагчаар дамжуулан даруй мэдээлж, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэхээр бэлтгэхэд нь эрх зүйн болон бусад шаардлагатай тусламж үзүүлэх,
 - III. Бусдын нөлөөнд автагдаагүй, хараат бус, эрх мэдэл бүхий байгууллага буюу шүүхээр асуудлыг хуулийн дагуу өмгөөлөгч буюу өөр зохих этгээдийн оролцоотойгоор уг хүүхдийн язгуур эрх ашигт харшлахаас бусад тохиолдолд түүний нас болон эцэг эх буюу хууль ёсны асран хамгаалагчийн байдлыг харгалзан шударгаар хэлэлцэж, шийдвэрийг шуурхай гаргаж танилцуулах,
 - IV. Гэрчийн буюу гэм буруугаа хүлээсэн мэдүүлэг гаргуулах гэж албадахгүй байх, биеэ дааж болон бусдын тусламжтайгаар яллах талын гэрчүүдийн мэдүүлэгтэй танилцах, өмгөөлөх талын гэрчүүдийг тэгш эрхтэйгээр оролцуулж, мэдүүлэгтэй нь танилцуулах,
 - V. Эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн гэж тооцогдсон хүүхэд тэрхүү шийдвэрийг болон түүний дагуу авсан арга хэмжээтэй холбогдох ямар ч асуудлыг бусдын нөлөөнд автагддаагүй, хараат бус, эрх мэдэл бүхий дээд шатны байгууллага буюу шүүхэд давж заалдах,
 - VI. Хүүхэд хэрэв шүүхийн таслан шийдвэрлэх ажлыг явуулж байгаа хэлээр ярьж чаддагүй буюу ойлгодоггүй бол орчуулагчийг үнэ хөлсгүйгээр авах,
 - VII. Хэрэг хэлэлцэх ажиллагааны бүх шатанд хүүхдийн хувийн амьдралыг бүрэн хүндэтгэх,
3. Оролцогч улсууд нь эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн гэгдэж ялагдсан буюу гэм буруутайд тооцогдсон хүүхдүүдэд шууд хамаарах хууль, журам тогтоох болон тусгай байгууллага, албан газрыг байгуулахад тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэх бөгөөд тухайлбал:
 - a. эрүүгийн хууль тогтоомж зөрчсөний төлөө хариуцлага хүлээлгэх насны доод хязгаарыг тогтоох,
 - б. шаардлагатай бөгөөд ингэх нь зохистой гэж үзсэн тохиолдолд ийм хүүхдүүдтэй хүний эрх хийгээд эрх зүйн баталгааг бүрэн сахисан нөхцөлд шүүн таслах ажиллагааны хүрээнээс гадуур харьцах.
4. Хүүхдийн амьжиргааны байдал, түүнчлэн гэмт хэргийн шинж байдалд тохируулан түүнтэй харилцах явдлыг хангах зорилгоор асрамжлах, асран хамгаалах болон хянан харгалзах тухай дүрэм мөрдөх, зөвлөлгөө өгөх үйлчилгээ үзүүлэх, туршилтын хугацаа тогтоох, хүмүүжил, сургалтын болон мэргэжлийн бэлтгэлийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн албан газруудын асрамжийг орлож чадахуйц бусад асрамжийн хэлбэр зэрэг олон янзын арга хэмжээ авах нь чухал.

Дөчин нэгдүгээр зүйл

Энэхүү Конвенцийн аль ч заалт нь хүүхдийн эрхийг хэрэгжүүлэхэд илүү дөхөм үзүүлж байгаа бөгөөд:

- a. оролцогч улсын хуульд, эсвэл

б. тухайн улсын хувьд дагаж мөрдөгдөж олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан аливаа заалтыг үл хөндөнө.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Дөчин хоёрдугаар зүйл

Оролцогч улсууд нөлөө бүхий зохистой хэрэгслийг ашиглан Конвенцийн зарчим, заалтуудын талаар насанд хүрэгчдэд болон хүүхдүүдэд өргөн мэдээлэх үүрэг хүлээнэ.

Дөчин гуравдугаар зүйл

1. Энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад олсон ахицын талаар хэлэлцэж байх зорилгоор хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн хороог байгуулах бөгөөд энэ хороо нь дор заасан үүргийг гүйцэтгэнэ.
2. Хорооны бүрэлдэхүүн ёс суртахууны эрхэм дээд чанарыг эзэмшсэн, энэхүү Конвенцид хамаарах асуудлаар нэрд гарсан арван мэргэжилтнээс бүрдэнэ. Хорооны гишүүдийг оролцогч улсууд өөрийн иргэдээс сонгох ба тэдгээр нь өөрийн нэрийн өмнөөс ажиллана. Чингэхдээ газар зүйн шуударга хуваарилалт болон эрх зүйн гол гол системд анхаарна.
3. Хорооны гишүүдийг оролцогч улсуудаас нэрийг нь дэвшүүлсэн хүмүүсийн жагсаалтаас нууц санал хураалтаар сонгоно. Оролцогч улс бүр өөрийн иргэдийн дотороос нэг хүний нэрийг л дэвшүүлж болно.
4. Хороог сонгох анхны сонгуулийг энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор явуулах бөгөөд дараа дараагийн сонгуулийг 2 жил тутамд нэг удаа явуулна. Сонгууль бүрийг явуулахаас наад зах нь 4 сарын өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга ороцогч улсуудад захидал илгээж, хоёр сарын хугацаанд хүмүүсийнхээ нэрийг дэвшүүлэхийг санал болгоно. Улмаар Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшигдсэн хүмүүсийн нэрсийг цагаан толгойн дэс дараагаар тэдгээрийн нэрийг дэвшүүлсэн орныг заан жагсааж, энэхүү Конвенцид оролцогч улсуудад толилуулахаар илгээнэ.
5. Сонгуулийг Ерөнхий нарийн бичгийн даргаас зарлан хуралдуулсан оролцогч улсуудын зөвлөлгөөн дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд явуулна. Оролцогч улсуудын гуравны хоёрын бүрэлдэхүүнтэй бол хүчинтэйд тооцогдох эдгээр зөвлөлгөөн дээр хамгийн олон буюу санал хураахад байлцаж оролцсон оролцогч улсуудын төлөөлөгчдийн үнэмлэхүй олонхийн санал авсан нэр дэвшигчийг Хорооны гишүүнээр сонгогдсонд тооцно.
6. Хорооны гишүүд дөрвөн жилийн хугацаагаар сонгогдоно. Тэдгээрийн нэрийг дахин дэвшүүлсэн тохиолдолд тэд дахин сонгогдох эрхтэй. Анхны сонгуулиар сонгогдсон таван гишүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жилийн дараа дуусах бөгөөд анхны сонгуулийг явуулж дууссан даруйд дээрх таван гишүүнийг зөвлөлгөөний дарга шодох журмаар тогтооно.
7. Хорооны аль нэг гишүүн нас барсан буюу огцорсон, эсхүл өөр шалтгаанаар Хорооны гишүүний үүргийг цаашид биелүүлж чадахгүйд хүрвэл тухайн хүний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс өөрийн иргэдийн дотроос Хорооны зөвшөөрснөөр өөр мэргэжилтнийг үлдсэн хугацаанд нь томилон ажиллуулна.
8. Хороо өөрийн дотоод дүрэм, журмыг батална.
9. Хороо албан тушаалтнуудаа хоёр жилийн хугацаагаар сонгоно.
10. Хороо чуулганаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд, эсхүл Хорооны тодорхойлсон аль нэг тохирох газарт хуралдуулна. Хороо нь дүрмийн дагуу жил тутам чуулна. Хороо чуулах хугацааг тодорхойлох, мөн шаардлагатай тохиолдолд өөрчлөх тухай асуудлыг энэхүү Конвенцид оролцогч улсуудын зөвлөлгөөн дээр Ерөнхий Ассамблей сайшаасан нөхцөлд шийдвэрлэнэ.
11. Энэхүү Конвенцийн дагуу Хороо үүргээ үр нөлөөтэй биелүүлэхэд шаардагдах хүн, хүч, материал хөрөнгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Хороонд олгоно.
12. Энэхүү Конвенцийн дагуу байгуулагдсан Хорооны гишүүд Ерөнхий Ассамблейгаас баталсны дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөрөнгөөр Ерөнхий Ассамблейн тогтоосон нөхцөл журмаар зохих цалин авна.

Дөчин дөрөвдүгээр зүйл

1. Оролцогч улсууд Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг бэхжүүлэх талаар авсан арга хэмжээ болон эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд гарсан ахиц өөрчлөлтийн тухай илтгэлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаа уламжлан Хорооны хэлэлцүүлэхээр дор заасан хугацааг баримтлан ирүүлж байх үүрэгтэй. Үүнд:
 - а. тухайн оролцогч улсын хувьд Конвенц хучин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор,
 - б. үүний дараа таван жил тутамд.
2. Энэ зүйлийн дагуу оруулах илтгэлд энэхүү Конвенцийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтийн байдалд нөлөөлж байгаа хүчин зүйл, бэрхшээл байгаа бол тэдгээрийн талаар дурдана. Түүнчлэн энэхүү Конвенц тухайн оронд хэрхэн дагаж мөрдөгдөж байгаа тухай Хороонд бүрэн ойлгуулахад хангалттай мэдээллийг илтгэлд оруулна.
3. Хороонд оруулсан анхны илтгэлдээ тухайн асуудлын бүх талыг тусгасан тохиолдолд оролцогч улсууд энэ зүүлийн нэгийн "б"-д заасны дагуу оруулах дараа дараачийн илтгэлд өмнө дурдсан гол зүйлийг дахин давтах шаардлагагүй.
4. Хороо нь энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж нэмэлт мэдээллийг оролцогч улсаас хүсэж болно.
5. Хороо нь Эдийн засаг, нийгмийн Зөвлөлөөр дамжуулан өөрийн үйл ажиллагааны талаар хоёр жилд нэг удаа Ерөнхий Ассамблейд илтгэл оруулна.
6. Оролцогч улсууд өөрийн илтгэлийн ил тод байдлыг улс орондоо өргөнөөр хангана.

Дөчин тавдугаар зүйл

Энэхүү Конвенцийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, Конвенцийн хамарч буй салбарт олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор:

- а. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, Хүүхдийн фонд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд багтах энэхүү Конвенцийн заалтуудын хэрэгжилтийн тухай асуудлуудыг хэлэлцэхэд төлөөлөгчөө оролцуулах эрхтэй. Өөрсдийн зохих бүрэн эрхийн хүрээнд багтах салбаруудад Конвенцийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар шинжээчдийн дүгнэлт гаргуулах нь зохистой гэж үзвэл Хороо Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, хүүхдийн фонд болон бусад эрх бүхий байгууллагад энэ талаар хүсэлт тавьж болно. Өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд багтах салбаруудад Конвенцийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар илтгэл бэлтгэж оруулахыг Хороо Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллагууд, Хүүхдийн фонд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллагаас хүсч болно.
- б. Хороо зохистой гэж үзвэл техникийн зөвлөлгөө буюу тусламж хүссэн, эсхүл эдгээр зөвлөлгөө тусламж шаардлагатай байгааг дурдсан оролцогч улсын аливаа илтгэлийг эдгээр хүсэлт, дурдагдсан зүйлийн талаар өөрийнхөө санал бодлын хамт Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага, Хүүхдийн фонд болон эрх бүхий бусад байгууллагад шилжүүлнэ.
- в. хүүхдийн эрхтэй холбогдсон зарим асуудлаар өөрийн нэрээр судалгаа явуулахыг Ерөнхий нарийн бичгийн даргад санал болгохыг Хороо, Ерөнхий Ассамблейд зөвлөж болно.
- г. Хороо нь энэхүү Конвенцийн 44, 45 дугаар зүйлүүдийн дагуу авсан мэдээлэлд үндэслэсэн санал, нийтлэг шинжтэй зөвлөмжийг гаргаж болно. Ийм санал, нийтлэг шинжтэй зөвлөмжийг сонирхсон аливаа оролцогч улсад шилжүүлж, хэрэв оролцогч улсуудаас санал бодлоо ирүүлсэн бол тэдгээрийн хамт Ерөнхий Ассамблейд мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР ХЭСЭГ

Дөчин зургадугаар зүйл

Энэхүү Конвенц бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

Дөчин долдугаар зүйл

Энэхүү Конвенцийг соёрхон баталбал зохино. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

Дөчин наймдугаар зүйл

Энэхүү Конвенцид бүх улс нэгдэн орж болно. Ийнхүү нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

Дөчин есдүгээр зүйл

1. Энэхүү Конвенцид нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хорь дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү Конвенцийг баталсан тухай хорь дахь батламж жуух бичиг буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш Конвенцийг баталсан буюу түүнд нэгдэн орсон аль ч улсын хувьд энэхүү Конвенц нь тухайн улсын батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш гуч хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Тавьдугаар зүйл

1. Энэхүү Конвенцийг хянан үзэх хүсэлтийг түүнд оролцогч аль ч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад гаргаж болно. Улмаар Ерөнхий нарийн бичгийн дарга гарсан хүсэлтийг оролцогч улсуудад хүргүүлж, түүнийг хэлэлцэж, санал хураах зорилгоор бага хурал хуралдуулах эсэх талаар саналаа мэдэгдэхийг хүснэ. Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш дөрвөн сарын дотор оролцогч улсуудын наад зах нь гуравны нэгээс цөөнгүй нь ийм бага хурал хуралдуулах саналыг дэмжвэл Ерөнхий нарийн бичгийн дарга Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор эл бага хурлыг зарлан хуралдуулна. Эл бага хуралд байлцаж, санал хураахад оролцсон улсуудын олонхийн санал авсан аливаа нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар Ерөнхий Ассамблейд оруулна.
2. Энэ зүйлийн нэгдүгээрт заасан журмын дагуу хэлэлцэгдсэн нэмэлт өөрчлөлт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаар батлагдаж, батлахын төлөө оролцогч улсуудын гуравны хоёроос цөөнгүйн саналыг авснаар хүчин төгөлдөр болно.
3. Хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлт нь түүнийг баталсан улсуудын хувьд хүчин төгөлдөр болж, заавал мөрдөгдөх ёстой бөгөөд харин оролцогч бусад улсын хувьд энэхүү Конвенцийн заалтууд, түүнчлэн өөрсдийнх нь баталсан өмнөх нэмэлт өөрчлөлтүүд хүчинтэй хэвээр байна.

Тавин нэгдүгээр зүйл

1. Энэхүү Конвенцийг батлах буюу түүнд нэгдэн орохдоо улсуудын хийсэн тайлбарын эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч, бүх улсад тарааж байх болно.
2. Энэхүү Конвенцийн зорилго, зорилгод үл нийцсэн тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.
3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад зохих ёсоор мэдэгдэх замаар тайлбарыг хэдийд ч эгүүлэн авч болох бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга энэ тухай бүх улсад мэдэгдэнэ. Энэ мэдэгдэл нь түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

Тавин хоёрдугаар зүйл

Оролцогч аль ч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх замаар энэ Конвенцийг цуцалж болно. Цуцлах тухай мэдэгдэл нь түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авсан өдрөөс хойш жилийн дараа хүчин төгөлдөр болно.

Тавин гуравдугаар зүйл

Энэхүү Конвенцийн эхийг хадгалагч нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга байна.

Тавин дөрөвдүгээр зүйл

Англи, араб, испани, хятад, орос, франц хэлээр үйлдсэн эх нь адил хүчинтэйд тооцогдох энэхүү Конвенцийн жинхэнэ эхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

Үүнийг баталж, өөр өөрсдийн засгийн газраас зохих бүрэн эрх олгогдсоныхоо дагуу дор гарын үсэг зурагчид энэхүү Конвенцид гарын үсгээ зурав.